

# 10

## ТӨГРӨГИЙН ХАНШНЫ БУУРАЛТ БА ХӨРВӨХ ЧАДВАР

### В. Нацагдорж

Мөнгөний ханш буурах нь зах зээлийн эдийн засгийн нэгэн ноцтой үзэгдэл, хэр хэмжээнээсээ хэтэрвэл өвчин болж эс эмчлэвээс эдийн засаг өөдөлж чадахгүй байдалд ордог. Эл өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх үүргийг Төр, Засгийн газар хүлээнэ.

Мөнгөний ханш буурах гэж улс орны эдийн засагт зайлшгүй хэрэгцээтэйгээс илүү хэмжээний мөнгө гүйлгээнд гарч мөнгө үнэгүйдэхийг хэлнэ. Мөнгөний ханшны бууралтыг түүний үнийн өөрчлөлтийн үзүүлэлтийн (индексийн) туслалцаатайгаар хэмжинэ. Хэрэглээний бүлэг барааны урьд жилийн үнийн түвшинг тулгуур болгон авч тухайн оны үнийн түвшинд харьцуулах замаар үнийн түвшингийн өөрчлөлтийн үзүүлэлтийг тодорхойлдог. Үүнээс гадна ханш бууралтын хурдац хэмээх үзүүлэлтийг хэрэглэх бөгөөд энэ нь тухайн жилийн үнийн өөрчлөлтөөс урьдах оны өөрчлөлтийн үзүүлэлтийг хасч тухайн жилийн үзүүлэлтэд хуваан 100-аар үржүүлсэнтэй тэнцүү байна.

Зах зээлийн эдийн засагт мөнгөний ханш буурах үзэгдлийг үүсэх шалтгааныг нь үндэс болгон **нэгд**, эрэлтээс, **хоёрт**, нийлүүлэлтээс үүдэх бууралт гэж баримжаалан ангилж үздэг.

Барааны хэт хомсдол нэг талаас, нөгөө талаас хэвийн хэмжээнээс хэтрүүлэн мөнгө гаргалт явуулснаас болж бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт хийж бүтээснээсээ буюу нийлүүлэлтээсээ хэтэрсний улмаас чөлөөт мөнгө эргэлдэн үнийн түвшин нэмэгдэхийг эрэлтээс үүдэх буюу эрэлтийн ханш бууралт гэдэг. Ийнхүү илүүдэл эрэлт нь бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэнд оруулж "Хэт олон мөнгө бага хэмжээний барааг ангуучлах" байдал үүсгэнэ.

Нийлүүлэлтээс үүдэх мөнгөний ханшны бууралт гэж үйлдвэрлэлийн материал, түүхий эдийн үнэ, цалин хөлс нэмэгдсэний улмаас бүтээгдэхүүний нэгжийн зардал



өсөж үйлдвэрлэгчид бүтээгдэхүүнийхээ үнийг нэмэх, эсвэл үйлдвэрлэлээ багасгаж гарцаагүй байдалд орохыг хэлнэ. Үнийн түвшин нэмэгдэх энэхүү үзэгдлийг зардлын өсөлтийн ханш бууралт гэх ба нэрлэсэн цалин, түүхий эд, эрчим хүчний үнийн өсөлт гол эх сурвалж нь болдог.

Мөнгөний ханш буурах дээрх хоёр төрлийг амьдрал дээр ялгах нь ихээхэн төвөгтэй учир эдийн засагчид энд доорх зарчмыг баримталдаг. Эрэлтийн ханш бууралт нийт нийлүүлэлт хэвийн байхад үүсч болох бол нийлүүлэлтийн ханш бууралт эрэлтийн өсөлттэй холбоотой үүснэ.

Ханш бууралтын механизм ямар ч саадгүй ажиллаж байгаа бол түүнийг задгай, харин Төр, Засгийн газраас ямар нэг хяналт, хязгаарлалт тогтоох нөхцөлд явагдах ханшны бууралтыг хяналт бүхий ханш бууралт гэдэг.

Задгай ханш бууралтын механизм бол бидний сайн мэдэх ханш бууралтын (үнэ өсөх) хүлээлт мөн. Энэхүү хүлээлт нь хадгаламжийг хорогдуулан урсгал эрэлтийг өсгөснөөр бараа, үйлчилгээ улам өндөр үнэтэй болно.

Мөнгөн хадгаламжийн бууралт нь зээлийн эх үүсвэрт нөлөөлж хөрөнгө оруулалт, улмаар үйлдвэрлэл, нийлүүлэлтийг сааруулна.

Үнийн түвшин өссөнөөр ажиллагсадын бодит орлого буурах учир тэдний хэвийн аж байдлыг хангахын тулд мөнгөн орлогыг нь нэмэгдүүлэх шаардлага гарна. Ийнхүү цалин хөлс нэмэгдсэнээр үйлдвэрлэлийн зардал өсч тэр нь үнэнд шахалт үзүүлнэ. Энэ маягаар задгай ханш бууралтын үед "Цалин-Үнэ" гэсэн битүү цагираг үүснэ. Энэ үед үнэ, орлогын өсөлтийн хурдацыг ялгаатай байлгаж зарцуулалтын ханш бууралтыг хяналтанд авч хэрэглэгчдийн хүлээх хохиролыг хамгийн бага хэмжээнд байлгах нь гол зорилт болно.

Үйлдвэрлэлийн бэлэн нөөцтэй, ажилгүйдэл бараг байхгүй эдийн засаг ханш бууралтад өртөх тал байдаг. Аль нэг салбарт эрэлт нэмэгдсэнээр үнэ өсөх нь тухайн салбарт хөрөнгө оруулах тохио болдог. Уул салбарын үйлдвэрлэл, борлуулалт нэмэгдсэнээр үнэ буурч ээлжит тэнцвэр тогтоно. Энэ байдал нь зах зээлийн эдийн засаг дахь хэвийн үзэгдэл мөн. Харин ханш бууралтаас үүдэн зах зээлийн тэнцвэр алдагдах үед ханш бууралтын механизмын үйлчилгээг саармагжуулахад чиглэсэн хэд хэдэн арга хэмжээ авах, тухайлбал үнэ, орлогыг түр хугацаанд царцмал байдалд барих, тэдгээрийн өсөлтийн дээд хязгаар тогтоох арга хэрэглэж болно. Эдгээр арга хэмжээгээр ханш бууралтыг задгай байдлаас хязгаартай хэв шинжид оруулна.

Манай орон зах зээлд шилжих үйл явцыг туулах замд явж байна. Энэ үеийн эхний 3-4 жилд үйлдвэрлэл, нийлүүлэлт уналтанд орж, харин 1994 оноос уналт ерөнхийдээ зогссон боловч үйлдвэрлэлийн цар хэмжээ 1989 оны түвшинд хүрч чадаагүй 2000 онтой золгосон билээ.

Энэ нөхцөлд барааны хомсдолыг ашиглан гадаадын (үнийн түвшин өндөртэй) барааг зах зээлийн үнээс нь ихээхэн илүү үнээр борлуулах болсон, нөгөө талаас дотоодын үйлдвэрлэл, нийлүүлэлт унаж материал, түүхий эдийг гадагш харьцангуй өндөр үнээр борлуулж эхлэсэн нь дотоодын зах зээлд үнийн түвшин дээшлэхэд хүргэжээ.

Үүнээс гадна дотоодын зах зээл дэх барааны хомсдол нь иргэдийн гар дээр бэлэн мөнгөний хуримтлал бий болж банкин дах хадгаламж үлэмж буурсан, үнийн түвшин огцом нэмэгдсэний улмаас мөнгө гаргалт (хүснэгт 1) өссөн нь бараа үйлчилгээний үнэ улам өсөхөд хүргэжээ. Жишээ нь 1992 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар 3.0 тэрбум орчим төгрөг иргэдийн гарт хуримтлагдсан нь мөнгө гаргалтыг нэмэгдүүлэх, бараа, үйлчилгээний үнэ өсөх үндсэн хөрс болжээ.

Хүснэгт № 1

Мөнгөний нийлүүлэлт, сая төг

Онууд	Гүйлгээндэх бэлэн мөнгө	Мөнгө M1	Мөнгө M2	Нөөц мөнгө
1989	581.1	3505.0	5082.6	
1990	742.7	4749.0	5633.2	
1995	28755.7	42636.5	10244.6	37507.7
1996	46095.8	64301.6	128395.3	51210.2
1997	56816.5	78107.9	170065.5	63017.1
1998	61754.2	825582.0	167249.6	74778.7

Төгрөгийн худалдан авах чадвар жилээс жилд, сараас сард унасан нь мөнгөний ханш уналтын хурдацыг гэрчилнэ. Хэрэв хэрэглээний барааны өөрчлөлтийг 1991 оны нэгдүгээр сарын 16-нд 100% гэж үзвэл 1995 он хүртэл хугацаанд дараах эвгүй байдал гарчээ (Хүснэгт №2).

Хүснэгт 2

Хэрэглээний барааны үнийн өөрчлөлт ба ханшны бууралт %

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	1991	1992	1993	1994	1995
Үнийн өөрчлөлт 1991 оны 1 дүгээр сарын 16-ны түвшинтэй харьцуулбал	152.7	649.8	1838	3058	4682
Урьдах сартай нь харьцуулбал					
Нэгдүгээр сар		103.6	126.7	109.5	103.6
Хоёрдугаар сар		109.8	107.9	106.9	102.7
Гуравдугаар сар		132.9	110.2	103.3	104.9
Дөрөвдүгээр сар		113.7	106.1	102.5	102.1
Тавдугаар сар		104.5	101.8	100.5	104.9
Зургаадугаар сар		124.0	128.5	100.0	100.2
Долоодугаар сар		109.1	105.2	115.1	115.7
Наймдугаар сар		101.6	108.6	98.78	100.5
Есдүгээр сар		108.6	103.6	103.8	102.9
Аравдугаар сар	103.2	129.7	105.8	107.4	102.9
Арваннэгдүгээр сар	105.1	110.1	105.2	103.2	101.8
Арванхоёрдугаар сар	104.4	111.0	102.5	102.1	102.1
Ханш уналтын хурдац Арванхоёрдугаар сар	1.13	76.5	64.6	50.4	



Хэрэглээний барааны үнийн түвшин 1991 оны нэгдүгээр сарын 16-ний хэмжээтэй харьцуулбал 1992 онд 6.5 дахин, 1993 онд 18.4 дахин, 1994 онд 30.6 дахин тус тус нэмэгдсэн байна.

Манай орны туулсан замнал болон зах зээл хөгжсөн орнуудын туршлагаас үзэхэд мөнгөний тухайлсан бодлогогүйгээр мөнгөний ханшны бууралтыг зогсоох боломжгүй нь ойлгогдож байна.

Мөнгөний бодлогыг тодорхойлохдоо доорх зүй тогтлыг харгалзан үзэх шаардлага гарах нь мэдээж. Үүнд: Мөнгөний нийлүүлэлт их болох үед мөнгөний зах зээл дээр зээл хүрэлцээтэй болж мөнгөний үнэ (хүүгийн хувь хэмжээ) буурна. Мөнгөний тоо хэмжээ нэмэгдэх өөр нэг шалтгаан бол төсвийн алдагдлыг нөхөхийн тулд Засгийн газарт зээл олгох тохиолдол мөн. Ханшны бууралт нь зах зээлийн механизмийн жигдрэлт, тухайлбал өрсөлдөөний дэглэм болон монополийн ноёрхолын зэрэг хэмжээнээс ихээхэн хамаарна. Монголын зах зээлд ихэвчлэн монополь үйлдвэрлэгч, худалдаачид ноёрхох аваас барааны үнэ ямар ч хаалт, саадгүй өсөх болно.

Ханш бууралтыг арилгахын тулд, нэг талаас, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн тогтвортой тэнцвэр тогтоох, нөгөө талаас ханш бууралтын механизмын эсрэг чиглэсэн арга ажиллагаа мөнгөний бодлогод тусгах ёстой.

Мөнгөний ханш бууралтын эсрэг ажиллагааг хоёр бүлэгт хуваан үзэж болох юм. Үүнд: нэгдүгээрт, алс хэтийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх аргыг нэгтгэсэн ханш бууралтын эсрэг стратеги боловсруулах, хоёрдугаарт, ханш бууралтын эсрэг хэрэгжүүлэх ойрын арга хэмжээг хамрах тактикийг тодорхойлж ажиллах шаардлагатай байдаг.

Мөнгөний ханш бууралтын эсрэг стратегийн нэг чухал зорилт бол ханш бууралтын хүлээлтийг, тухайлбал үнийн өсөлтийг хүлээх хэвшлийг зогсооход оршино. Уг зорилтыг хэрэгжүүлэх доор дурьдах хоёр нөхцлийг бүрэлдүүлэх нь чухал болдог байна. Үүнд: нэгд, зах зээлийн тогтолцооны механизмийг бүх талаар бэхжүүлэх, хоёрт, ханш бууралтыг үл жолоодогдох уналтад хүргэхгүй байж чадах Засгийн газрын үйл ажиллагаа эрхэм болно.

Нэгдэх нөхцөлийг хангахын тулд импортын бүтээгдэхүүний гаалийн болон бусад хязгаарлалтыг сулруулах, бага хэмжээний үйлдвэр худалдааг урамшуулан дэмжих, зах зээлийн ажиллагаанд тогтмол хяналт тавьж монополь ажиллагааг цаг тухайд нь зогсоох, үнийг чөлөөтэй байлгах зэрэг арга хэмжээ шаардана.

Хоёрдахь нөхцөлд хамаарах үндсэн асуудал бол урт хугацааны мөнгөний зөв бодлого мөн. Мөнгөний бодлогын гол агуулга нь мөнгөний нийт хэмжээний жил тутмын өсөлтөд хатуу хязгаар тогтооход оршино. Мөнгөний жил тутмын өсөлтийг үйлдвэрлэлийн бодит өсөлтийн хурдац, ханш бууралтын байж болох түвшинг бодолцон тогтооно. Ялангуяа манай орон шиг эдийн засгийн уналтыг хэтлэхийн төлөө яваа орны хувьд мөнгөний цэгцтэй бодлого тэргүүлэх үүрэгтэй юм.

Мөнгөний ханш бууралтын эсрэг зохицуулалтын өөр нэг чухал стратеги зорилт бол төсвийн алдагдлыг хорогдуулах, үүний тулд төсвийг үйлдвэрлэлийн цар хэмжээний өсөлттэй уялдуулах нь зүйтэй. Уул зорилтыг татварыг нэмэгдүүлэх, эсвэл төр, засгийн газрын зардлыг хорогдуулах замаар хэрэгжүүлж болох бөгөөд алиныг нь давуутай байлгахыг эдийн засгийн цаг үеийн зорилттой холбон шийдвэрлэдэг.

Татварын тогтолцоог боловсронгуй болгох нь ханш бууралтын эсрэг стратегийн нэгэн чухал зүйл хэмээн үзээд манай улсын Парламент албан татварын багц хууль гаргаж түүнд олон талын нэмэлт, өөрчлөлт оруулсаар ирэв. Харин төсвийн зардлыг хорогдуулах үндсэн зарчим гэвэл зах зээлийн тогтолцоонд шилжүүлэн ажиллуулж болох аж ахуйн чанартай үйл ажиллагааг төрөөс санхүүжүүлэхийг зогсооход оршино. Үүнд: төрөөс хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хэт оролцохоос татгалзах, төсвийн хөрөнгө оруулалтын харьцангуй хэмжээг багасгах арга хэмжээ хамаарна.

Мөнгөний ханш бууралтын эсрэг хэрэглүүр болгон үндэсний валютын ханшийг нэмэх практик ажиллагаа байж болдог. Ийм тохиолдолд гадаадаас орж ирэх бараа, үйлчилгээний үнэ хорогдож эдийн засаг дахь үнийн түвшин доошлох учиртай. Үндэсний валютын ханш дээшилснээр импортын үнэ буурах хандлага илрэх боловч экспорт зайлшгүй үнэд орж гадаад зах зээлд хүндрэл үүснэ. Ийнхүү худалдааны болон төлбөрийн тэнцэл муудахад хүрнэ.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих нэг чухал нөхцөл нь ялангуяа Монгол улсын хувьд эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа учир Төр, Засгаас тунхагласан нээлттэй эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх явдал билээ. Дээрх зорилтыг хэрэгжүүлэх угтвар нөхцөл бол төгрөгийн хөрвөх чадвар мөн. Үндэсний мөнгөн нэгжийн хөрвөлт гэж үндэсний мөнгөн нэгжийг гадаад орны валютаар, гадаад валютыг үндэсний валютаар солилцох харьцаа буюу боломжийг хэлдэг. Валют солилцооны ханш нь валютын зах зээл дэх эрэлт нийлүүлэлтээс хамаарна.

“Хөрвөлт” нь тухайн улс оронд валютын хязгаарлалт байгаа эсэхтэй шууд холбоотой ойлголт мөн. ОУВС-ийн тодорхойлсноор валютын хязгаарлалт гэж валютын солилцоо, олон улсын тохиролцсон төлбөр хийх үед зардлыг өсгөх зэргээр албан ёсны байгууллагын зүгээс нөлөөлөх дурын үйл ажиллагааг хэлдэг байна. Валютын хязгаарлалт, үндэсний валютын хөрвөх чадвар хоёр хоорондоо урвуу хамааралд оршино.

Валютын хязгаарлалтын хамгийн дэлгэрэнгүй хэлбэр бол валютын солилцооны олон янзын ханш мөн. Тухайлбал, эдийн засгийн гадаад тохиролцооны хэв шинжийг харгалзан үндэсний мөнгөн нэгжийн солилцооны хэд хэдэн янзын харьцааг Засгийн газраас тогтоодог. Жишээ нь: бараа худалдааг нэг ханшаар (урьдчилан тогтсон), хөрөнгө оруулалтыг өөр ханшаар (зах зээлийн буюу арай чөлөөтэй) тооцдог. Энэ байдлын зорилго нь гадаадаас авах чухал хэрэгцээний барааны дотоодын үнэ хэт өсөхөөс болгоомжлох, “бодит” эдийн засагт тогтворгүй байдал үүсгэгч дамлах ажиллагааг хязгаарлах, засгийн газарт гадаад валютын нөөцийг хадгалахад оршдог.



Ер нь валютын хөрвөлтийг валют эзэмшигчийн амьдарч буй нутаг орныг харгалзан дотоод, гадаад гэж ялгадаг. Дотоод хөрвөлт гэж тухайн орны харъяат, харъяалалгүй боловч тэр оронд амьдрагч иргэдэд үндэсний мөнгөө дурын гадаад валютаар солихыг, гадаад хөрвөлт гэж гадаадын иргэд болон хуулийн этгээд тухайн оронд бий болгосон мөнгөн хөрөнгөө дотоод зах зээл болон гадагш ашиглах боломж олгохыг тус тус ойлгоно. Тэдэнд нутгийн валютыг бусад валютаар сольж шилжүүлэх баталгаа олгох бол тухайн орны иргэн тийм боломж байхгүй байна.

Мөнгөний хөрвөлтийг дотоод, гадаад гэхийн зэрэгцээ бүрэн, хэсэгчилсэн гэж ялгадаг. Бүрэн хөрвөлт нь дотоод, гадаад хөрвөлтийг бүх л хэмжээгээр хамрах учир хэсэгчилсэн хөрвөлтөөс ялгагдана. Бүрэн хөрвөлт гэж үндэсний мөнгөн нэгжийг бүх хуулийн этгээд, иргэд байгаа гадаад валютаар солихыг хэлнэ. Ийнхүү үндэсний валютыг гаргана, оруулна. Ингэснээр тухайн орны мөнгөн нэгж олон улсын тооцоонд төлбөрийн хэрэгсэлийн үүрэг гүйцэтгэх болно.

Валютын хөрвөлт нь тухайн улс орны үйлдвэрлэлийн түвшингээс хамааралтай байдаг. Гадаад хөрвөлт нь өрсөлдөөнийг хурцатган эдийн засгийн бүтцийг өөрчилж үйлдвэрлэгч орноос ашгийг гадагш гаргахад нөлөөлдөг.

Эрэлт хангалтгүй байх үед хөгжин буй орнуудын төв банк солилцооны албан ёсны ханшийг хадгалах гурван үндсэн хувилбар ашиглаж байна. Тэдгээр банк

**нэгд**, өөрийн валютын нөөцийг хорогдуулах буюу нэмэгдэл зээл олох, ингэснээр улам өртэй болох замаар илүүтэй эрэлтэд зохицохыг оролдох,

**хоёрт**, импортын эрэлтийг (төлөөс, тоон хязгаарлалт, зөвшөөрлөөр дамжуулан) хорогдуулахыг зорьсон худалдаа, татварын бодлого явуулан гадаад валютын илүү эрэлтийг багасгахыг оролдох,

**гуравт**, гадаад валюттай холбоотой зах зээлийн ажиллагаанд оролцон зохицуулах үүргийг гүйцэтгэж байна. Иймэрхүү зохицуулалтыг валютын хяналт гэж нэрлэдэг.

Солилцооны дээгүүр ханш нь орон нутгийн валютаар илэрхийлэгдэх импортын үнийг чөлөөт валютын зах зээлд бий болох түвшингээс (эрэлт нийлүүлэлтээс тодорхойлогдох) доогуур хэмжээ хүртэл хорогдуулна. Хөрөнгө оруулалтын болон завсрын барааны импортын хямдруулалтыг үйлдвэржилтийг урамшуулахад ашиглана. Гэтэл, солилцооны дээгүүр ханш нь хэрэглээний бараа, ялангуяа үнэт эдлэлийн гадаад валютаар тооцсон үнийг зэрэг хорогдуулна. Иймэрхүү хэрэгцээгүй, үнэтэй импортыг хязгаарлах хүсэлтэй хөгжиж буй орнуудад импортод хяналт тогтоох буюу солилцооны давхар ханшны тогтолцоо хэрэглэх болдог.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд нэг ам доллартай харьцах төгрөгийн ханш ихээхэн өөрчлөгдсөн (хүснэгт 3) нь эдийн засгийн шилжилтийн эхний үе шатанд Засгийн газар валютын ханшийг тогтмол байлгах бодлого баримтлаж байгаад 1993 оны 5 дугаар сараас чөлөөт ханш хэрэглэх болсонтой холбоотой болно.

Валютын ханш, 1 ам доллар=төг

онууд	оны эцэс	өмнөх онтой харьцуулбал
1989	3	
1990	7	2.3 дахин
1991	40	
1992	40	100%
1993	396	9.9 дахин
1994	414	4.4%
1995	474	
1996	694	
1997	814	
1998	956	9.4%
1999	999	435%

Солилцооны тогтмол ханшны зарчмаар бол гадаад орны төв банкууд доллараар үнэлсэн тогтмол ханшаар өөрийн валютыг худалдах, худалдан авахад үргэлж бэлэн байдаг.

Гадаад орны төв банк нь доллар болон доллараар худалдаж болох алтны бэлтгэл нөөцтэй байх ба долларын илүүдэл эрэлт байх үед зах зээлд гаргах нь байдаг. Эсрэгээр, долларын илүүтэй нийлүүлэлтийн үед валютыг худалдан авах нь бий.

Энэ нь төв банк гадаад валютыг худалдан авах, худалдах ажиллагаа бөгөөд Төв банкнаас явуулах эрчимтэй ажиллагааны (интервенцийн) шаардлагат хэмжээг төлбөрийн тэнцлийн байдлаар тодорхойлдог. Төв банкны алт валютын нөөц хүрэлцээтэй байх үед өөрийн валютын ханшийг тогтвортой байлгахын тулд валютын зах зээл дээр дээрх ажиллагааг үргэлжлүүлж чадна. Гэвч улс орон төлбөрийн тэнцэл нь байнгын алдагдалтай бол төв банкны алт валютын нөөц нь нимгэрэн, эрчимтэй ажиллагаа явуулж чадахгүй байдалд оршино.

Валютын тогтсон ханшны зарчим мөрдөх үед төв банкууд төлбөрийн тэнцлийн тэнцвэрт байдлыг хангахад шаардлагатай гадаад валютын хэрэгтэй тоо хэмжээг гаргах ёстой бол валютын уян ханшны зарчим мөрдөх үед гадаад валютын эрэлт, нийлүүлэлт тэнцвэртэй байх түвшинд ханш тогтоогдож байхыг төв банк зөвшөөрөн хүлээдэг.

Чөлөөт хөвөх ханшны зарчим мөрдөх үед валютын солилцооны ханш валютын зах зээл дэх эрэлт нийлүүлэлтээр чөлөөтэй тогтоогдож төв банкуудын оролцоо бүрэн алга болно. Энэ нь цэвэр хөвөлтийн нөхцөлд төлбөрийн тэнцлийн үлдэгдэл тэгтэй тэнцүү байдаг. 1993 оноос үйлчлэх болсон валютын уян ханшны зарчим мөрдсөн нь амьдрал дээр тавьсан зорилгод хараахан хүрээгүй учир зохицуулалт бүхий хөвөх тогтолцоо үйлчлэх болжээ. Зохицуулалттай хөвөлтийн үед төв



банкууд солилцооны ханшид нөлөөлөх оролдлого болгон гадаад валютыг худалдан авах, худалдах эрчимт ажиллагаа явуулна.

Валютын ханшны тухай онцгой, зарим үед будилж болох, хэлээр ярьдаг. Ялангуяа улс хоорондын худалдаа, санхүүгийн тухай нэг ч маргаан тойрон өнгөрөхгүй үнэгүйдэл (обесценение), үнэд орох (удорожание), ханшийг зориудаар бууруулах (девальвация), үндэсний валютын ханшийг зориудаар нэмэгдүүлэх (ревальвация) гэсэн нэр томъёотой тохиолдоно.

Тогтсон ханшны дэглэмтэй үед улсын түвшинд шийдвэрлэсний үр дүнд гадаад валютын үнэ дээшлэх тохиолдолд ханшны зориултын бууралт явагдана. Энэ нь ханш нь буурсан валютад гадаадынхан одоогийнхоос бага төлж, тэр орны иргэд бусад орны валютанд их төлбөр төлнө гэсэн хэрэг юм. Үүний эсрэг ажиллагааг ханший зориудаар нэмэгдүүлэх гэдэг.

Валютын хөвөх ханшны дэглэмийн үед гадаад валютын үнэ өөрчлөгдөхийг валют үнэгүйдэх буюу үнэд орох гэж нэрлэнэ. Хөвөх ханшны дэглэмийн үед бусад валютаар үнэлсэн түүний үнэ хорогдвол валют үнэгүйднэ.

Эсрэгээр, бусад валютаар илэрхийлсэн түүний үнэ буурч байвал валют үнэд орж байна гэж үздэг. Хэдийгээр эдгээр нэр томъёог хоёр янзын дэглэмд тухайлбал, валютын тогтсон болон хөвөх ханштай харьцуулан ашиглаж байгаа боловч эдийн засгийн утга нь адил юм. Эдгээр нь валютын ханшний өөрчлөлтийн чиглэлийг тодорхойлж байна.

Энд өгүүлсэнээс доох дүгнэлт хийж болно. Үүнд:

**Нэгдүгээрт:** Монгол дахь эдийн засгийн уналтын эхний үед барааны хомсдол үүссэнээр мөнгөний харьцангуй илүүдэл бий болж төгрөгийн ханш гэнэт буурсан бол эх орны элдэв төрлийн түүхий эдийг үнийн өндөр түвшинтэй орнуудад борлуулан өргөн хэрэглээний барааг ихээр импортлож эхэлснээр тус орны зах зээлд үнийн өндөр түвшин тогтсон бөгөөд энэ үед үйлдвэрлэлийн уналт, өмч хувьчлалын алдаанаас үүдэн ажилгүйдэл газар авснаар хүн амын мөнгөн орлогын хуваарилалт жигд бус болж улмаар баян ядуугийн ялгарал хүчтэй явагдан мөнгө цөөн хүний гарт бөөгнөрөн энэ байдал нь өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэх, мөнгөний ханш буурах нөхцөлийг бүрдүүлжээ.

**Хоёрдугаарт,** мөнгөний хөрвөлт нь тухайн орны мөнгөний ханш мөнгөн зах зээлийн байдал, ялангуяа төлбөрийн тэнцлээс ихээхэн хамаардаг байна. Мөнгөн зах зээлийн, тухайлбал ханш бууралтын байдал нь үндэсний мөнгөн нэгжийн хөрвөлтийн тодорхойлогч хүчин зүйл мөн. Төгрөгийн хөрвөх чадварыг хангах гол арга зам гэвэл мөнгөн зах зээлийн гадаад валютын хангамжийг эрс нэмэгдүүлэх, үндэсний валютын ханш бууралтыг зогсоох явдал болж байна.